



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/579

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын 131 дүгээр сургуулийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалт, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дүгээр сарын 03-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. ОББТМ ХХК болон эцэг эхчүүдээс хандивласан нийт 5,420,000.00 (таван сая дөрвөн зуун хорин мянга) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 131 дүгээр сургууль (Ө.Дуламсүрэн)-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 131 дүгээр сургууль (Ө.Дуламсүрэн)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын
 даргын 2024 оны 11 дугаар сарын 11-ны
 өдрийн А/С.9 дугаар тушаалын хавсралт

Бүртгэлд авах хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Нийслэлийн ерөнхий боловсролын 131-р сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт, хүчин чадал	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны		Хандивлагч байгууллага		
							Нэгж үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр	
1	6 настны сурагч ширээ		Шаргал, модон	2024	ш	32	100,000.00	3,200,000.00	ОББТМ ХХК	Хандив	
2	6 настны сурагч сандал		Шаргал, модон	2024	ш	32	60,000.00	1,920,000.00			
Тавилгын дүн								5,120,000.00			
1	Цэвэр усны аппарат	Номелух	4 литр	2024	ш	1	300,000.00	300,000.00	Эцэг эхчүүд	Хандив	
Тоног төхөөрөмжийн дүн								300,000.00			
Үртгэлд авах хөрөнгийн нийт дүн:								5,420,000.00			